

**ЦАЛИН, ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ БОЛОН
ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ОРЛОГО, ШУУД БУС
ОРЛОГО, ХӨРӨНГӨ БОРЛУУЛСНЫ ОРЛОГОТӨЙ ХУВЬ ХҮН ОРЛОГЫН
АЛБАН ТАТВАРАА ТАЙЛАГНАХ ГАРЫН АВЛАГА**

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

ХЭН ТАЙЛАН ГАРГАХ ВЭ?

а. Хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал тэдгээртэй адилтгах орлого, бүхий хувь хүн /ХХОАТ-ын тухай хуулийн 7-р зүйл/

- ✓ ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого
- ✓ ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого
- ✓ ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг
- ✓ төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого
- ✓ гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого
- ✓ үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого
- ✓ хоол, унааны мөнгө

б. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй татвар ногдох шууд бус орлого бүхий хувь хүн

- ✓ үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн
- ✓ орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр
- ✓ үзвэр үйлчилгээний олговор
- ✓ ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр
- ✓ ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр
- ✓ арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү
- ✓ ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж
- ✓ гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр
- ✓ Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр
- ✓ эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл

- ✓ дээр дурьдсантай адилтгах бусад орлого.

в. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого олсон хувь хүн

- ✓ үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого
- ✓ газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого
- ✓ хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого
- ✓ хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого
- ✓ Биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого

ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

ТЕГ-ын даргын А/164 тоот тушаалаар батлагдсан Хувь хүний орлогын албан татварын ТТ-06 тайлангийн маягт нь

- ✓ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ /ХМ-06(1)/
- ✓ Шууд бус орлогын мэдээ /ХМ-06(2)/
- ✓ Үйл ажиллагааны орлогын мэдээ /ХМ-06(3)/
- ✓ Хөрөнгийн орлогын мэдээ /ХМ-06(4)/
- ✓ Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын мэдээ /ХМ-06(5)/
- ✓ Бусад орлогын мэдээ /ХМ-06(6)/
- ✓ Албан татвараас чөлөөлөгдөх орлогын мэдээ /ХМ-06(7)/
- ✓ Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/
- ✓ Татвар ногдохгүй орлогоос хасагдахгүй зардлын мэдээ /ХМ-06(8б)/
- ✓ Албан татварын хөнгөлөлтийн тооцооллын мэдээ /ХМ-06(9)/
- ✓ Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараа хасаж тооцох мэдээ /ХМ-06(10)/ хавсралт мэдээнээс бүрдэнэ.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, ажил олгогчоос олгосон татвар ногдох шууд бус орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого олсон албан татвар төлөгч ТТ-06 тайланг гарах бол:

- ✓ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ /ХМ-06(1)/
- ✓ Шууд бус орлогын мэдээ /ХМ-06(2)/
- ✓ Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын мэдээ /ХМ-06(5)/- г тус тус бөглөхөд үндсэн тайлан бэлэн болно.
- ✓ Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/
- ✓ Татвар ногдохгүй орлогоос хасагдахгүй зардлын мэдээ /ХМ-06(8б)/ хавсралтуудыг тус тус бөглөхөд үндсэн тайлан бэлэн болно.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ /ХМ-06(1)/

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ /ХМ-06(1)/								
(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)								
Д/Д	Ажил олгогчийн		Орлогын төрөл	Орлогын дүн	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн дүн	Ногдуулсан татварын дүн	Хуулийн 23.1-д заасан албан татварын хөнгөлөлтийн дүн	Суутгуулсан татвар
	ТТД	нэр						
А	Б	В	Г	1	2	3=(1-2)*10%	4	5
1			Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого					
2			Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого					
3			Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг					
4			Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого					
5			Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого					
6			Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого					
7			Хоол, унааны мөнгө					
			Нийт дүн					

Хуульд заасны дагуу ажил олгогч буюу суутган төлөгч албан татварыг суутган авч төсөвт төвлөрүүлдэг.

Хавсралт мэдээний орлогын төрөл баганын орлогын төрлөөс сонгож 1 болон 2 дугаар бананын харгалзах мөрөнд орлогын дүнг бичнэ. Ингэснээр

3-р багананд нийт дүнгээр татагдана.

4-р баганад зөвхөн хуулийн 23.1-т заасан хөнгөлөлтийн дүн ХМ-06(9)-р мэдээнээс татагдана.

5-р баганад хувь хүний орлогын албан татварын суутгуулан төлсөн дүн байна.



Татварын ерөнхий газрын даргын
2012 оны 10 сарын 29-ны өдрийн
А/164 дугаар тушаалын 1 хавсралт

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Маягт ТТ-06

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

ТТ-ийн дугаар: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []
 ТТ-ийн нэр: _____ Утас: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []
 Тайлант хугацаа: он [] [] [] улирал [] [] Факс: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол [x] энд тэмдэглэнэ үү.
 (оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
А. Татвар ногдуулах орлого, зардлын тооцоолол		
1. Нийт орлого (2+3+4+5+6+7)	1	
1.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	2	
1.2. Албан татвар ногдох шууд бус орлого	3	
1.3. Үйл ажиллагааны орлого	4	
1.4. Хөрөнгийн орлого	5	

Хавсралт мэдээ /ХМ-06(1)/-г бөглөснөөр тайлангийн 2-р мөр буюу Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого дүн автоматаар татагдана.

Шууд бус орлогын мэдээ /ХМ-06(2)/

Шууд бус орлогын мэдээ /ХМ-06(2)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Ажил олгогчийн		Орлогын төрөл	Орлогын дүн	Ногдуулсан албан татвар	Суугтуулсан татвар
	ТТД	нэр				
А	Б	В	Г	1	2=(1*10%)	3
А. Албан татвар ногдох шууд бус орлого /Хуулийн 11.1-д заасан/						
1			Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн			
2			Орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр			
3			Үзвэр үйлчилгээний олговор			
4			Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр			
5			Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр			
6			Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү			
7			Ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж			
8			Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр			
9			Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр			
10			Эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл			
11			Адилтгах бусад орлого			
Нийт дүн						

Хуульд заасны дагуу Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, ажил, үйлчилгээний орлогыг шууд бус орлогод хамруулах бөгөөд тухайн орлогын нийт дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна.

Татварын ерөнхий газрын даргын
2022 оны 10 сарын 29 ны өдрийн
А/164 дугаар тушаалын 1. хавсралт

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Маягт ТТ-06

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

ТТ-ийн дугаар: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []
 ТТ-ийн нэр: _____
 Тайлант хугацаа: он [] [] [] улирал [] []

Утас: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []
 Факс: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол [x] энд тэмдэглэнэ үү.
 (оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлтүүд		Мөр	Дүн
I		II	III
A. Татвар ногдуулах орлого, зардлын тооцоолол			
1. Нийт орлого (2+3+4+5+6+7)		1	
1.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		2	
1.2. Албан татвар ногдох шууд бус орлого		3	
1.3. Үйл ажиллагааны орлого		4	
1.4. Хөрөнгийн орлого		5	

Хавсралт мэдээ /ХМ-06(2)/-г бөглөснөөр тайлангийн 3-р мөр буюу Албан татвар ногдох шууд бус орлогын дүн автоматаар татагдана.

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын мэдээ /ХМ-06(5)/

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын мэдээ /ХМ-06(5)/
 (оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Суутгагчийн		Орлогын төрөл	Татвар ногдох орлого	Хасагдах зардал	Татвар ногдуулах орлого	ногдуулах албан татвар		Суутгуулсан татвар	Суутгуулаагүй татвар
	нэр	ТТД					хувь	дүн		
А	Б	В	Г	1	2	3=(1-2)	4	5=(3*4)	6	7=(5-6)
1			Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого				2%			
2			Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого				10%			
3			Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого				10%			
4			Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого				10%			
			Нийт дүн							

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг

- Үл хөдлөх эд хөрөнгө борлуулж олсон орлогыг нийт дүнгээр нь тодорхойлж 2 хувиар албан татвар ногдуулна. /зардал хасахгүй/

Хавсралт мэдээний Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого гэсний 1-р баганын харгалзах мөрөнд нийт орлогын дүнг оруулахад 5-р багананд төлбөл зохих татварын дүн тооцоологдох бөгөөд хуульд заасны дагуу суутгуулан төлсөн бол 6-р баганын харгалзах мөрөнд татварын дүнг оруулна.

- Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос
 - а.эрх авахтай холбогдуулан төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох зардал
 - б.хөрөнгийг худалдаж, шилжүүлж авах болон тэдгээртэй холбогдуулан төлсөн баримтаар нотлогдох зардлыг хасаж гарсан дүнд 10 хувиар албан татвар ногдуулна.
- Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогоос уг хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээр тодорхойлж 10 хувиар албан татварыг ногдуулна.

Хавсралт мэдээний Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого гэсний 1-р баганын харгалзах мөрөнд орлогын дүн, хасагдах зардал болох 2-р багананд дээр дурдсан хасагдах зардлын дүнг тус тус оруулснаар 5-р багананд төлбөл зохих татварын дүн тооцоологдох бөгөөд хуульд заасны дагуу татвар төлөгч өөрөө тайлагнаж төлөх тул 7-р баганын харгалзах мөрөнд төлбөл зохих татварын дүнг оруулна.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН		
ТТ-ийн дугаар: [] [] [] [] [] [] [] [] [] [] []	Утас: [] [] [] [] [] [] [] [] [] [] []	
ТТ-ийн нэр: _____	Факс: [] [] [] [] [] [] [] [] [] [] []	
Тайлант хугацаа: он [] [] [] улирал [] []		
Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол <input checked="" type="checkbox"/> энд тэмдэглэнэ үү. (оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)		
Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
А. Татвар ногдуулах орлого, зардлын тооцоолол		
1.Нийт орлого (2+3+4+5+6+7)	1	
1.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	2	
1.2. Албан татвар ногдох шууд бус орлого	3	
1.3. Үйл ажиллагааны орлого	4	
1.4. Хөрөнгийн орлого	5	
1.5. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	6	
1.6. Бусад орлого	7	

Хавсралт мэдээ /ХМ-06(5)/-г бөглөснөөр тайлангийн 6-р мөр буюу Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого дүн автоматаар татагдана.

Хэрэв хөрөнгө борлуулсан, шилжүүлний орлогоос хасагдах зардалтай бол:

1. Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлний орлого, хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос хасаж тооцох эрх авахтай холбогдуулан төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох зардал, хөрөнгийг худалдаж, шилжүүлж авах болон тэдгээртэй холбогдуулан төлсөн баримтаар нотлогдох зардал
2. Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогоос уг хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардал гарсан бол Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/, Татвар ногдохгүй орлогоос хасагдахгүй зардлын мэдээ /ХМ-06(8б)/-г бөглөнө.


Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/

Хавсралт мэдээ /ХМ-06(8а)/ Хасагдах зардлын мэдээний зардлын төрөл баганаас сонгож 1-р бананын харгалзах мөрөнд зардлын дүнг бичнэ. Тухайн зардлын дүн нь төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн худалдан авалтын баримтын дүнг татна. Хэрэв ибаримтгүй буюу төлбөрийн баримтгүй бол тухайн зардлын дүнг Хавсралт мэдээ /ХМ-06(8б)/-ний 1-р мөр буюу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1-т заасан нөхцлийг хангаагүй зардал мөрөнд бичнэ.

Хавсралт мэдээ /ХМ-06(8б)/ Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын мэдээний зардлын төрөл баганаас сонгож 1-р бананын харгалзах мөрөнд хасагдахгүй зардлын дүнг бичнэ.

Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/		
(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)		
Д/Д	Зардлын төрөл	Дүн
А	Б	1
1	Цалин хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, түүнтэй адилтгах орлого /ХХОАТ ногдуулж суутгасан байх/	
2	Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл	
3	ХХОАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан олгосон шууд бус орлого /ХХОАТ ногдуулж суутгасан байх/	
4	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл	
5	Албан томилолтын зардал /Төрийн албан хаагчийн албан томилолтын зардлыг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрээгүй дүн/	
6	Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал /Холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байх/	
7	Ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал /тухайн татварын жилд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ болон контракт байгуулан ажиллаж байгаа ажиллагчдад олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрээгүй дүн/	
8	Даатгагчаас бусад этгээдийн сайн дурын даатгалын хураамж /татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрээгүй дүн/	
9	Урсгал засварын зардал /сэлбэг хэрэгслийн зардлыг багтаасан бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрээгүй дүн/	
10	Хувийн зардал /АНХАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу төлбөрийн баримтгүй зардал/	

Татварын ерөнхий газрын даргын
2019 оны 12 сарын 29-ны өдрийн
А/64 дугаар тушаалын 1 хавсралт



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Маягт ТТ-06

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

ТТ-ийн дугаар: _____ Утас: _____
 ТТ-ийн нэр: _____ Факс: _____
 Тайлант хугацаа: он [] [] [] улирал [] []

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол энд тэмдэглэнэ үү.
 (оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
А. Татвар ногдуулах орлого, зардлын тооцоолол		
1. Нийт орлого (2+3+4+5+6+7)	1	
1.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	2	
1.2. Албан татвар ногдох шууд бус орлого	3	
1.3. Үйл ажиллагааны орлого		
1.4. Хөрөнгийн орлого		
1.5. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого		
1.6. Бусад орлого		
2. Татвараас чөлөөлөгдөх орлого		
3. Чөлөөлөлтийн дараах албан татвар ногдох орлого	9	
4. Нийт зардал /11+12/	10	
4.1. Хасагдах зардал	11	
4.2. Хасагдахгүй зардал	12	
5. Татвар ногдуулах орлого /9-11/	13	

- Хасагдах зардлын мэдээ **/ХМ-06(8a)/**-ний зардлын дүн нь тайлангийн 11-р мөрөнд татагдана.

-Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын мэдээ **/ХМ-06(8б)/**-ний зардлын дүн нь тайлангийн 12-р мөрөнд татагдана.

ХЭРХЭН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДАХ ВЭ?

2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж байгаа ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйл 23.14-т “Албан татварын хөнгөлөлтийг энэ хуульд заасан эцсийн хугацаанд тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй бөгөөд энэ хуулийн 23.1, 23.9-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлтийг 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно” гэж заасан..

Иймд тайлант хугацаанд ногдуулан төлөхөөр тайлагнаж, хуулийн 26 дугаар зүйлд заасан хугацаанд төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн албан татварын хөнгөлөлт эдлүүлэхгүй бөгөөд мөн хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгох хэлбэрээр шийдвэрлэнэ.

Албан татварын хөнгөлөлтийн тооцооллын мэдээ /ХМ-06(9)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)				
Д/д	Хөнгөлөлтийн төрөл	Мөр	Тооцоолол	Дүн
А	Б	В	1	2
1. Хуулийн 23.1, 23.9 дэх хэсгээр				
1.1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулах албан татварт үзүүлэх хуулийн 23.1-т заасан хөнгөлөлт	1	Ажилласан сар Сард ногдох хөнгөлөлт Хөнгөлөгдөх татвар	
1.2	Дараах орлогод ногдох албан татварын хөнгөлөлт а. донорын олговор б. даатгалын нөхөн төлбөр в. Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал	2	Татвар ногдох орлого Хөнгөлөгдөх татвар	
Хэсгийн дүн		3		
2. Хуулийн 23.1, 23.9-д зааснаас бусад				
2.1	Дараах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар: а. үр тариа б. төмс, хүнсний ногоо, түүний үр в. жимс жимсгэнэ, түүний үр, суулгац г. тэжээлийн ургамал д. модны суулгац	4	Татвар ногдох орлого Хасагдах зардал Татвар ногдуулах орлого Ногдсон татвар Хөнгөлөлтийн хувь Хөнгөлөгдөх татвар	50%
2.2	Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт	5	Зээлийн хүүгийн зөрүүд төлсөн дүн Хөнгөлөгдөх татвар	
2.3	Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	6	Мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн төлбөрийн дүн Хөнгөлөгдөх татвар	
2.4	Монгол Улсын иргэн суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, коллежид анхлан суралцагчийг энэ хуулийн 23.5-д заасан хөнгөлөлт	7	Мэргэжлийн сургуулийн төлбөрийн дүн Хөнгөлөгдөх татвар	
2.5	Өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, жийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	8	Баримтаар нотлогдож байгаа төлбөр Хөнгөлөгдөх татвар	
2.6	Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	9	Татвар ногдох орлого/хандив/ Хөнгөлөгдөх татвар	
2.7	Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн энэ хуулийн 6.3.2-т заасан орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар	10	Татвар ногдох орлого Хасагдах зардал Татвар ногдуулах орлого Ногдсон татвар Хөнгөлөлтийн хувь Хөнгөлөгдөх татвар	
Хэсгийн дүн		11		
2.8	Монгол Улсын иргэн өөрийн албан татвар ногдсон орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар зөвхөн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол ийнхүү орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	12	Орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан мөнгөн дүн Хөнгөлөгдөх татвар	≤ 6,0 сая
Хэсгийн дүн /орон сууц/		13		
Нийт дүн (мөр 3+11+13)				

ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан албан татварын хөнгөлөлтийг төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй гэж заасан тул тухайн татварын жилд орлого олсон тухай бүр хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан төлбөрийн баримтаар нотлогдох зардлыг хасаж ногдуулсан албан татварыг хуульд заасан хугацаанд төсөвт төлнө.

Жишээ: Иргэн А тайлант жилд

- Цалин, хөдөлмөрийн хөлсний орлого - 10,0 сая төгрөг
- Ажил олгогчоос олгосон татвар ногдох шууд бус орлого - 2,0 сая төгрөг
- Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого - 20,0 сая төгрөг
- Газрын эзэмших эрх борлуулсны орлого - 5,0 сая төгрөг
- Нийт зардал - 3,0 сая төгрөг

Үүнд: Хасагдах зардал /баримтаар нотлогдох газрын эзэмших эрхийг анх худалдан авсан үнэ, худалдах, худалдан авах гэрээ болон төлсөн татвар/ - 3,0 сая төгрөг

- Тайлант хугацаанд ногдуулан төлсөн албан татвар 0,9 сая төгрөг.
- Их, дээд сургууль суралцдаг оюутан хүүхдийнхээ сургалтын төлбөрт 4,5 сая төгрөг төлсөн.

ХХОАТ-ын Т-06 тайлан гаргах

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ /ХМ-06(1)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Ажил олгогчийн		Орлогын төрөл	Орлогын дүн	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн дүн	Ногдуулсан татварын дүн	Хуулийн 23.1-д заасан албан татварын хөнгөлөлтийн дүн	Суугуулсан татвар
	ТТД	Нэр						
А	Б	В	Г	1	2	3=(1-2)*10%	4	5
1	1111111	Х	Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого	10 000 000	1 150 000	885 000	216 000	669 000
2			Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого					
3			Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг					
4			Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого					
5			Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого					
6			Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого					
7			Хоол, унааны мөнгө					
			Нийт дүн	10 000 000	1 150 000	885 000	216 000	669 000

Шууд бус орлогын мэдээ /ХМ-06(2)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/ Д	Ажил олгогчийн		Орлогын төрөл	Орлогын дүн	Ногдуулсан албан татвар	Суутгуулсан татвар
	ТТД	нэр				
А	Б	В	Г	1	2=(1*10%)	3
А. Албан татвар ногдох шууд бус орлого /Хуулийн 11.1-д заасан/						
1	1111111	Х	Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн	2 000 000	200 000	200 000
2			Орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр			
3			Үзвэр үйлчилгээний олговор			
4			Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр			
5			Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр			
6			Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү			
7			Ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж			
8			Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр			
9			Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр			
10			Эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл			
11			Адилтгах бусад орлого			
Нийт дүн				2 000 000	200 000	200 000

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын мэдээ /ХМ-06(5)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/ Д	Суутгагч-чийн		Орлогын төрөл	Татвар ногдох орлого	Хасагдах зардал	Татвар ногдуулах орлого	ногдуулах албан татвар		Суутгуулсан татвар	Суутгуулаагүй татвар
	нэр	ТТД					хувь	дүн		
А	Б	В	Г	1	2	3=(1-2)	4	5=(3*4)	6	7=(5-6)
1	Х	11	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	20 000 000		20 000 000	2%	400 000	400 000	
2			Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	5 000 000	3 000 000	2 000 000	10%	200 000		200 000
3			Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого				10%			
4			Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого				10%			
Нийт дүн				25 000 000	3 000 000	22 000 000		600 000	400 000	200 000

Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/д	Зардлын төрөл	Дүн
А	Б	1
1	Газрын эзэмших эрхийг худалдан авсан	3 000 000
	Нийт дүн	3 000 000

Албан татварын хөнгөлөлтийн тооцооллын мэдээ /ХМ-06(9)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/д	Хөнгөлөлтийн төрөл	Мөр	Тооцоолол	Дүн
А	Б	В	1	2
1. Хуулийн 23.1, 23.9 дэх хэсгээр				
2.3	Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	6	Мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн төлбөрийн дүн	4 500 000
			Хөнгөлөгдөх татвар	450 000
	Хэсгийн дүн	13		450 000
	Нийт дүн (мөр 3+11+13)			450 000

- ✓ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ /ХМ-06(1)/
- ✓ Шууд бус орлогын мэдээ /ХМ-06(2)/
- ✓ Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын мэдээ /ХМ-06(5)/- г тус тус бөглөхөд үндсэн тайлан бэлэн болно.
- ✓ Хасагдах зардлын мэдээ /ХМ-06(8а)/
- ✓ Татвар ногдохгүй орлогоос хасагдахгүй зардлын мэдээ /ХМ-06(8б)/ хавсралтуудыг тус тус бөглөхөд үндсэн тайлан дараах байдлаар бэлтгэгдсэн байна.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
А. Татвар ногдуулах орлого, зардлын тооцоолол		
1. Нийт орлого (2+3+4+5+6+7)	1	37 000 000
1.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	2	10 000 000
1.2. Албан татвар ногдох шууд бус орлого	3	2 000 000
1.3. Үйл ажиллагааны орлого	4	
1.4. Хөрөнгийн орлого	5	
1.5. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	6	25 000 000
1.6. Бусад орлого	7	
2. Татвараас чөлөөлөгдөх орлого	8	
3. Чөлөөлөлтийн дараах албан татвар ногдох орлого /1-8/	9	
4. Нийт зардал /11+12/	10	3 000 000
4.1. Хасагдах зардал	11	3 000 000
4.2. Хасагдахгүй зардал	12	
5. Татвар ногдуулах орлого /9-11/	13	34 000 000
Б. Албан татварын тооцоолол		
6. Ногдуулсан албан татвар	14	1 685 000
7. Хуулийн 23.1, 23.9-д заасан албан татварын хөнгөлөлт	15	216 000
8. Хасаж тооцох гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар	16	
9. Төлбөл зохих албан татвар /14-15-16/	17	1 469 000
10. Тайлант хугацаанд төлсөн албан татвар /19+20/	18	
10.1. Хуулийн дагуу бусдад суутгуулан төлсөн албан татвар	19	1 289 000
10.2. Тайлант хугацаанд хуулийн дагуу ногдуулан төлсөн албан татвар	20	200 000
11. Эцсийн төлбөл зохих албан татвар /17-18/	21	0
В. Албан татварын хөнгөлөлт, буцаан олголтын тооцоолол		
12. Хуулийн дагуу тооцсон албан татварын хөнгөлөлт /23+24+25/	22	450 000
12.1. Хуулийн 23.4-т зааснаас бусад албан татварын хөнгөлөлт	23	450 000
12.2. Орон сууцны албан татварын хөнгөлөлт	24	
12.3. Өмнөх оны тайлангаар шилжүүлэн тооцох албан татварын хөнгөлөлт	25	
13. Албан татварын хөнгөлөлт эдлүүлж, буцаан олгохоор тооцсон албан татвар	26	450 000
13.1. Төлбөл зохих албан татварт шилжүүлэн тооцсон	27	
13.2. Буцаан олгох хөнгөлөлт /26-27/	28	450 000
14. Албан татварын хөнгөлөлт эдлүүлэхгүй татвар	29	
15. Дараагийн татварын жилд шилжүүлэн тооцох албан татварын хөнгөлөлт /22-26-29/	30	
16. 2006 онд батлагдсан хуулийн дагуу дараагийн татварын жилд татвар ногдох орлогоос чөлөөлөх орлого	31	

Тайлбар: Татвар төлөгч татварын тайлангаа гаргаж, төлсний дараа буцаан олгодог байхаар хуульд заасан. Дээрх жишээгээр тооцооллын дагуу төлбөл зохих албан татварыг бүрэн төлж татварын өргүй тул 450 000 төгрөгийн хөнгөлөлтийг эдэлж буцаан авахаар байна.

/Хэрэв тухайн татвар төлөгч татварын өрийг бүрэн төлөөгүй бол 450 000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт эдлэн буцаан авах боломжгүй болох байв./

ТАТВАР ТӨЛӨГЧИД ҮЙЛЧЛЭХ ГАЗАР